

## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	3
2. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, биелэлт .....	7
3.1. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил:.....	9
3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил...	10
3.3. Хөрс, ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд.....	10
3.4. Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ...	10
3.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	13
3.6. Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс .....	13
3.7. Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	13
3.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .....	14
ДҮГНЭЛТ .....	17

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ


### Төслийн товч танилцуулга

“Өвөр шарангад” талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос урагш 335 км, Мандалговь хотоос урагш 60 км зайд тус тус байрлана.

- Талбайн нэр: “Өвөр шарангад”
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн дугаар: MV-021920
- Ашиглалтын талбайн хэмжээ: 393.7га

### Хүснэгт 1. Талбайн солбицол

Булангийн цэгийн дугаар	Газарзүйн солбицол, град WGS-84	
	Өргөрөг	Уртраг
1	45° 09' 41.13"	106° 02' 00.58"
2	45° 09' 41.13"	106° 01' 42.95"
3	45° 10' 00.59"	106° 01' 42.95"
4	45° 10' 00.59"	106° 02' 00.58"



Зураг 1. Талбайн байршлын тойм зураг



Зураг 2. Уурхайн ерөнхий байдал



## Геологийн тогтоц

Өвөр шарангад нэртэй хайлуур жоншны талбайд түрүү пермийн насны интрузив чулуулаг нь талбайн ихэнх хувийг эзлэх бөгөөд зүүн хойд, зүүн болон төвийн хэсгээр их хэмжээгээр тархжээ. Агаарын зурагт тод цайвар өнгөөр ялгагдана. Талбайн зүүн хойд, зүүн болон төвийн хэсгээр гарш муутай сэвсгэр хурдас ихтэй учир зурагт муу тайлагдана. Өмнөх ажлаар уг интрузивийг дараахи 3 фазаар хуваавал манай орд нь I-р фазад багтана.

1. I фаз. Пироксен эвэр хуурмаг биотиттой габбродиорит /vδP1/

Түрүү пермийн насны эдгээр чулуулаг дотор баруун хойш сунасан хагарлыг дагаж 1-2 м хүртэл зузаантай бараг өргөргийн дагуу чигтэй кварцын брекчүүдээр дүүргэгдсэн, бутралын бүс дайран өнгөрдөг. Кварцын энэхүү бутралын брекчлэгдсэн бүс дотор баруун хойш чигтэй 325<sup>0</sup>-ын азимутаар сунаж тогтсон 922м хүртэл урт үргэлжлэх кварц флюоритын судал тааралдана. Энэ жоншны судал нь баруун урдаас зүүн хойшоо 55<sup>0</sup>-аар унах бөгөөд зузаан нь 0.72-1.83м-ийн хооронд хэлбэлзэх ба дундаж зузаан нь 1.83м байдаг.

2019-2020 онуудад Өвөр шарангад хайлуур жоншны орд дээр өөрийн хөрөнгөөр “Очир мандал хайрхан” ХХК-ний хайгуулын анги хүдрийн биетийн суналын дагуу газрын гадаргуугаас 50-96 м зайтай, 30 м дундаж урттай, 1.2 м өргөнтэй нийт 7 сувгийг экскаватороор 1.5 м дундаж гүнтэй ухсан. Нийт 7 суваг буюу 234.4 м<sup>3</sup> уулын цулыг ухаж, нийт 450 т.м өрөмдлөгийн ажил, зохих дээжлэлтийн ажлууд зэргийг хийж гүйцэтгэсэн. 1:2000-ны масштабтай топо зураглалын, Археологийн судалгаа, Палеонтологийн судалгаа зэрэг ажлуудыг тус тус гэрээ хийж гүйцэтгүүлсэн. Энэ ажлынүр дүнд нөөцийг 2 хүдрийн биетээр тогтоосон. Ордын хэмжээнд бодитой В зэрийн 69.31%-ийн CaF<sub>2</sub>-ийн дундаж агуулгатай 18.87 мян.тн хүдэрт 13.08 мян.тн флюорит, боломжтой С зэрийн 72.43%-ийн CaF<sub>2</sub>-ийн дундаж агуулгатай 12.4 мян.тн хүдэрт 8.98 мян.тн флюорит, буюу нийт бодитой болон боломжтой (В+С) зэргийн 70.55%-ийн CaF<sub>2</sub>-ийн дундаж агуулгатай 31.28 мян.тн хүдэрт 22.07 мян.тн флюоритын нөөцийг тогтоон улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

## Зам харилцаа ба дэд бүтэц

Төслийн талбай нь Дундговь аймгийн Мандалговь хотоос 60 км, УБ хотоосзүүн урагш 335км, засаг захиргааны мужлалаар Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт оршино. Монгол Улсын босоо тэнхлэгийн Улаанбаатар-Өмнөговийн АО201-р код бүхий асфальтан замаар Улаанбаатар хотоос Мандалговь хот хүртэл 335 км явж түүнээс цааш 60 км шороон замаар явж төслийн талбайд хүрнэ. Орон нутгийн шинж чанартай замаар тухайн талбайд аль ч талаас нь жилийн 4 улиралд хүрэх бүрэн боломжтой. Замын нөхцөл сайн гэж хэлж болно.

Өвөр шарангад хайлуур жоншны ордод 35 кВт-ын өндөр хүчдэлийн шугам талбайгаас баруун тийш 10км зайтай дайран өнгөрдөг.

Газар зүй: Физик газарзүйн мужлалаар Төв Монголын тал хээрийн бүс, Өмнөт Монголын говь хээрийн бүсийн заагт оршдог. Энэ бүс нутаг голдуу тал газар, намхан жижиг толгодоос бүрдэнэ. Ажлын талбай нь газарзүйн хувьд далайн түвшингээсдээш 1100-1200 м өндөрт оршино. Баруун хойноос зүүн урагш чиглэлтэй янз бүрийн жижиг хөндийнүүд, ам жалгуудаар хэрчигдсэн рельефтэй. Өвөр шарангад хайлуур жоншны орд нь 1150 м байрлана.

Талбайг хүрээлсэн жижиг уул толгодуудаас эргэн тойрон дахь орчныг 5-10 км хүртэл зайд харах боломжтой. Талбайн зүүн хойт хэсэг илүү толгодорхог гадаргуутай ба 25-40 м хооронд өндөршил нь хэлбэлздэг байна. Талбайн гадаргууд чулуулгийн илрэх гарш нь гүвээ толгодын оройгоор дэл судал хэлбэртэй оршино.

Ус зүй: Талбайд гадаргуугийн усан сүлжээ харьцангуй муу хөгжсөн. Төслийн талбайн эргэн тойронд Дунд жирийн худаг, Гашууны худаг, Зэстийн худаг, өрөмдмөл худгууд, 2-10км зайд байршдаг. Худгуудын усны ундарга ихэвчлэн 0.1-0.8 л/с хэлбэлзэх бөгөөд газрын гүнээс тэжээгдэнэ. Хүнсний зориулалттай усны хэмжээ энэ нутагт нэлээд хүндрэлтэй юм. Учир нь нэлээд олон тооны худгууд байдаг боловч усны шинжилгээгээр тэр болгон ундны усны шаардлага хангадаггүй.

Зун намрын улиралд бороо орсны улмаас жижиг хонхрууд усаар дүүргэгдэж бага хэмжээний нуурыг үүсгэдэг ба сарын сүүл хүртэл үргэлжилдэг байна. Газрын хөрс 1- 1.5м-т хөлдөх ба 6-р сар хүртэл үргэлжилдэг.

Ургамал: Хөрсний бүтэц нь тархалтын байдлаараа талбайн хэмжээнд харьцангуй жигд тархалттай. Ургамлын хөрсний үеийн зузаан 0.05-0.2 м хааяа 0.4 м хүрдэг.Тал хөндий, энгэр бэл газраар таана, хөмүүл, агь зэрэг говийн шимт ургамлаас гадна шарилж зангуу, толгодын орой, хажуу бэлээр хялгана, хазаар өвс ургана. Говирхог хэсгээрээ нохойн шийр, алтан харгана, дэрс, буйлс, бударгана зэрэг бутлаг ургамал ургадаг.

**Ан амьтан:** Төслийн талбайн орчимд ан амьтад нэлээд элбэг бөгөөд ихээхэн хэмжээгээр тохиолдох амьтдаас цагаан зээр орно. Түүнчлэн бусад өвсөн тэжээлтэн, мэрэгчид, шавж, хэвлээр явагчид, жигүүртэн шувуудаас гадна махчин амьтад тохиолдох нь элбэг. Махчин амьтдад үнэг, хярс, мануул, дорго, зараа, ховроор чоно байдаг бол өвсөн тэжээлтнээс цөөн тоогоор хар сүүлт, зарим хэсгээр тарвага бий.

Дулааны улиралд тогоруу, ангир зэрэг шувууд нүүдэллэн ирдгээс гадна нутгийн хэмжээнд байнга амьдардаг шувуудаас элээ, хэрээ, тас, сар, бүргэд, ногтруу, тагтаа, чогчиго, болжмор, харцага, зэргийг нэрлэж болно.

## **2. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, биелэлт**

Тус уурхайг ил аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ашигт малтмалын газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг 2021 оны 11-р сарын 24-ны өдрийн Т/226 тоот тушаалаар, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу 2022 онд “Найчрал састайнэблэ” ХХК боловсруулж БОАЖЯ-аар батлуулсан. 2022 оны уулын ажлын төлөвлөгөөг 4-р сард баталгаажуулан 6- сард байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталгаажуулсан болно. 2022 оны Байгаль орчны хяналт шинжилгээний тайланг “Ногоон эко мандала” ХХК боловсруулан холбогдох дээжүүдийг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн байна.

Өвөр шарангад нэртэй хайлуур жоншны ордыг 2022 онд ил аргаар ашиглахад, 8.88 мян.тн хүдэр олборлох ба ФР маркийн жоншны хүдэр 8.88 мян.тн-г баяжуулах үйлдвэрт нийлүүлнэ .

### **Ашиглалтын систем**

Ордын геологи болон уул техникийн нөхцөл талаас гадаад овоолго бүхий тээвэртэй ашиглалтын системийн хэрэглэнэ. Уулын ажлын ерөнхий чиглэл дээрээс доош чиглэсэн байна. Ашиглалтын технологийн үндсэн параметрууд:

Ажлын доголын өндөр - м 5

Ажлын бус доголын өндөр - м 10

Уурхайн ерөнхий хажуугийн өнцөг - град 45

Ажлын бус доголын хажуугийн өнцөг - град 60

Ажлын доголын хажуугийн өнцөг - град 60

Аюулгүйн бермийн өргөн – Уурхай-1 - м 5.2

Аюулгүйн бермийн өргөн – Уурхай-2 - м 5.9

Ажлын талбайн хамгийн бага өргөн - м 25

### **2022 оны уулын ажил**

#### **Уурхайн хүчил, чадал ашиглах хугацаа**

Уурхай нь бүрэн хүчин чадалдаа хүрэхийн тулд газрын дээрх байгууламжийн ажил, ил уурхай зэрэг ажлууд хийгдэж ашиглалтын жилд 8.885 мян.тн хайлуур жонш олборлохоор төлөвлөсөн болно.

#### **Уурхайн ажиллах горим**

Жилд ажиллах хоногийн тоо 120 байна. Уулын ажлыг 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжтэй байна.

#### **Ил уурхайн процесс**

Ил уурхайн процесс нь уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолт, овоолго байгуулах

болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулна.

Ил уурхайд дараах процессууд явагдана: Үүнд

- Шимт хөрс хуулалт
- Өрөмдлөг, тэсэлгээ
- Ухаж ачих
- Тээвэрлэх
- Овоолох

### 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

#### 3.1. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил:

Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх зааварчилгааг тогтмол өгч мөрдүүлж ажилласан ба 2022 оны БОМТ-д тусгагдсан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

#### Хүснэгт 2. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслыг тогтоосон хугацаанд нь сольж байх.	Компанийн захирал	250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн масло, маслын шүүр, агаар болон, түлшний шүүрүүдийг байнга сольж байсан. Үйл ажиллагааны зардалд орсон
2	Уурхайн ашиглалтын үед тоосжилт дарах зорилгоор усалгааг тогтмол хийх.		Усалгааг тогтмол хийж байсан. 500.0 мян төгрөг
3	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээний ажлыг хийлгэх	Уурхайн дарга	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг 8-р сард хийлгэсэн.
4	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлөх		Агаарын бохирдлын төлбөр төлсөн
	Нийт		500.0 мян төг



### 3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил

#### Ус, усан орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

Ус ашиглах гэрээг 2022 оны 12-р сарын 6-ны өдөр Дундговь аймгийн Өлзийт сумын засаг даргатай гэрээ байгуулсан.

### 3.3. Хөрс, ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд

#### Хүснэгт 3. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажлууд

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Газар эзэмших гэрээгээ орон нутагтай байгуулан төлбөрөө төлөх.	Компанийн захирал	Хүсэлтээ өгсөн бөгөөд Иргэдийн хурлаар батлагдсан бөгөөд Засаг даргын захирамж хүлээгдэж байна.
2	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Уурхайн дарга	Бохирдсон хөрс, шатах тослох материалын хог хаягдлыг Чойр-т байрлах өөрийн засварын газарлуу зөөвөрлөх арга хэмжээ авч ажилласан
	Нийт зардал		- мян.төг

#### Хүснэгт 4. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн дарга	Тусгай зөвшөөрлийн талбай болон орон нутагт тогтсон маршрутаар зорчсон бөгөөд гарц таних тэмдэг байршуулсан
2	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байршуулсан.	Уурхайн дарга	Багаж хэрэгсэлд нийт 500.0 төгрөг
3	Орд орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа	Компанийн захирал	Орд орчмын хяналт шинжилгээний ажлыг 8-р сард хийж гүйцэтгэсэн бөгөөд зардал нь хяналт шинжилгээ, мониторингийн зардалд орсон.
	Нийт		500.0

### 3.4. Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	1.75 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.	Уулын инженер	Олборлолтын ажил төлөвлөсөн хугацаанд эхлээгүй тул тус нөхөн сэргээлтийг 2023 онд хийхээр байна.
2	Шимт хөрс хадгалах хамгаалах		1947.м <sup>3</sup> шимт хөрс хадгалах хамгаалах ажил хийгдэв. 2000.0 мян.төгрөг
3	Сумын нутаг дэвсгэрт орон нутгаас зааж өгсөн нөлөөлөлд өртөж эвдэрсэн 0.2 га газарт нөхөн сэргээлт хийнэ.		Хариуцлагатай уул уурхайн хүрээнд эвдэгдэж орхигдсон 0.2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Зардал нь 7000.0мян.төг
4	2022 онд орон нутгаас зааж өгсөн талбайд мод сөөг тарималжуулахаар төлөвлөв.		Тусгай зөвшөөрлийн талбайд улиас, үхрийн нүд зэрэг 500 ш мод бут тарималжуулсан. 850.0 мян.төгрөг зарцуулсан.
	Нийт зардал		9850.0 мян.төг



**Зураг 3. Мод тарималжуулсан байдал**



### 3.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

#### Хүснэгт 5. Хог хаягдлыг менежментээр хийгдсэн ажлууд

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан зайлуулах.	Компанийн захирал	2022 оны 10-р сарын 6 нд Засаг дарга Б. Галсандоржтой гэрээ байгуулсан. 592.0 мян.төгрөг
2	Хог хаягдлын төлбөрөө төлөх.		Заасан газраас өөр газар хог хаяагүй.
3	Ахуйн хаягдлыг хаях цэг байгуулах.		Өөрийн байгууллагын эргэн тойронд 50м газрыг тогтмол цэвэрлэж байсан.
4	Хог хаягдлын гэрээнд заасны дагуу эзэмшил газрын ойролцоо талбайг цэвэрлэх		Хотхоны зам талбай, уурхайлалтын хэсэгт гэрэлтүүлэг нэмсэн. Дотоод зардалд орсон
5	Орчин тойрондоо гэрэлтүүлэг хийсэн.		
Нийт зардал			<b>592.0 мян.төгрөг</b>

### 3.6. Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс

Ордын ашиглалтын талбай түүний ойр орчимд түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс байхгүй болно.

### 3.7. Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Тус төсөл нь химийн бодис ашиглаагүй.

### 3.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулсан. Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажилласан.

#### Хүснэгт 6. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн удирдлага зохион байгуулалтын ажил

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хариуцсан эзэн	Тайлбар, зарцуулсан зардал мян.төг
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөж ажилласан.	Уурхайн дарга	Дотоод төлөвлөлтөөр
2	Газрын төлөв байдлын хянан баталгааг 2021 онд “Эрхэм газар” ХХК буюу Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ газрын мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. Байгаль орчны аудитыг хийлгэх хуулийн хугацаа болоогүй тул 2022 онд хийлгээгүй 2024 онд хийлгэхээр төлөвлөж байна.		
3	Нөлөөллийн бүсийн иргэд болон сумын холбогдох хүмүүст 2022 оны 11-р сард тайлан танилцуулсан		



### 3.9. Хяналт шинжилгээний ажлын биелэлт

№	Хяналт шинжилгээний дээж	Хяналт шинжилгээний үзүүлэлт	Хяналт шинжилгээ явуулсан хугацаа	Хяналт шинжилгээ явуулсан байршил	Хяналт шинжилгээ хийсэн багаж, холбогдох стандарт
1	Агаар	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, Хүхэрлэг хий, Азотын давхар исэл	8 сард	Уурхайн хотхон Засварын талбай ШТС Хүдэр буулгах талбай Уурхайн карьер,	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007 Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 Агаарын тоосжилтыг Dusttrak 8530 Шинжилгээний аргын стандарт, MNS 17.2.5.12:88 MNS 17.2.5.11:88
2	Ус	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , CO <sub>3</sub> , HCO <sub>3</sub> )	8 сард	Гүний худаг	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус 4943:2015,
3	Хөрс	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл (Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	8 сард	ШТС Засварын талбай Технологийн зам хүдэр буулгах талбай кемп	- MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл - MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох - MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам - MNS(ISO)4814:1999. Атом Шингэлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

2022 оны Орчны Хяналт Шинжилгээний ажлыг тус оны 8-р сард Байгаль орчны үнэлгээ, зөвлөгөөний “Ногоон Эко Мандала” ХХК хийж гүйцэтгэсэн.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, хөрс, агаарын шинжилгээг хийлгэсэн.

**Агаар:**

Агаарын чанарын хэмжилт нь агаарын чанарын стандарт MNS 4585:2016-аас тоосны агууламж болон азот, хүхэрлэг хийн агууламжаар хэтэрсэн үзүүлэлт байхгүй.

**Ургамал:**

Цөлийн хээрийн үндсэн бүлгэмдэл болох баглуур–улаан бударганат бүлгэмдэлтэй. Гуу жалгаараа хармагт, бударганат зэрэг хагас сөөглөг ургамалын ургамалжилтай.

БОНХАЖЯ-ны 2015 оны 282 дугаар сайдын тушаалаар батлагдсан Ашигт ургамлын жагсаалтад ховор тархалтай 1 зүйл (*Zygodphyllum rotaninii*- потанини улаан тулам), элбэг тархалттай 7 зүйл (*Allium polyrrhizum*–таана, *Convolvulus ammonii*- Аммоний сэдэргэнэ, *Peganum nigellastrum*-өмхий өвс, *Rheum nanum*- намхан бажууна) ургамал ургана. Бэлчээрийн талхагдал бага.

**Хөрс:**

Хөрсөн дээр хүнд металл илрээгүй. Цаашид засварын талбайг цементлэхийг зөвлөсөн.

**Ус:**

Тус талбай Шарангад нэртэй ойролцоо байдаг худгаас ундны усаа зөөврөөр авдаг. Ундны усны химийн шинжилгээг “Монгол ус” ТӨҮГ-ын Усны Төв лабораторид шилжүүлсэн. Тухайн шинжилгээг монгол улсын ундны усны стандарт, чанар эрүүл ахуйн шаардлага MNS 0900-2018-тай харьцуулсан. Тус худгийн уснаас химийн болон бактериологийн шинжилгээ хийлгэсэн нь стандартаас давсан үзүүлэлт байхгүй.

**Хүснэгт 9. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал**

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	500.0
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	-
3	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	500.0
4	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	592.0
5	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	639.3
6	Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах, мод тарималжуулах ажилд	9850.0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	3000.0
8	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	Дотоод зардал
	<b>2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн</b>	<b>13081.3</b>

## ДҮГНЭЛТ

“Очир мандал хайрхан” ХХК-ийн “Өвөр шарангад” хайлуур ордын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт байрладаг.

Уурхайн ус ашиглах, хог хаягдлын гэрээг Засаг даргатай 2022 оны 10-р сарын 6-ны өдөр байгуулсан.

1.75 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж байсан ч уурхайн олборлолтын ажил төлөвлөсөн хугацаанд эхэлж амжаагүй тул тус талбайд 2023 онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж байна.

Биологийн нөхөн сэргээлт 2022 онд төлөвлөөгүй бөгөөд 1947 м<sup>3</sup> шимт хөрс хадгалж хамгаалах ажил хийгдсэн.

Дүйцүүлэн хамгаалах ажлын хувьд Очир мандал хайрхан ХХК нь 2022 онд орон нутгийн саналын дагуу эвдэгдэж орхигдсон 0.2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.

Тусгай зөвшөөрлийн талбайд улиас, үхрийн нүд тарималжуулсан.

2022 оны Орчны Хяналт Шинжилгээний ажлыг тус оны 8-р сард Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний эрх бүхий “Ногоон Эко Мандала” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн. Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, агаарын тоосжилт, хөрс, усны шинжилгээ хийсэн.

2022 оны 12-р сарын байдлаар Нийт 2022 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **13.08 сая төгрөг** зарцуулсан байна.



ХААН БАНК

Огноо/Date: 2022-06-06 14:11:04

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын/Journal No: 14834888

Гүйлгээний дугаар/POID: 000265073033

Системийн огноо/System Date: 2022-06-06

Дт	IBAN Дансны/Картын дугаар IBAN Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	MN07000500 5077316179	БАТЛУГА ДЭЛГЭРМАА	12,500,000.00 MNT	1.00
/ Арван хоёр сая таван зуун мянган төгрөг /				
Кт	Банкны дугаар/Branch No MOFUMNUB	Банкны нэр/Bank Name STATE FUND		
	IBAN Дансны/Картын дугаар IBAN Account/Card Number MN780090 100900013406	Нэр/Name БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	12,500,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

**ОЧИР МАНДАЛ ХАЙРХАН ХХК РД:3435474 , MV-21920 ЛИЦЕНЗИЙН БОМТ 50% НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БАРЬЦАА ТӨЛБӨР**

**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Суваг/Channel: INST

Гарын ёсэг/Signature:

Тамга/Stamp:

\_\_\_\_\_ Он/Year (YYYY) \_\_\_\_\_ Сар/Month (MM) \_\_\_\_\_ Өдөр/Day (DD)

Сурталчилгаа/Advertisement:





**“ОЧИР МАНДАЛ ХАЙРХАН” ХХК**  
ГАДААД, ДОТООД ХУДАЛДАА,  
УУЛ УУРХАЙ

Хаяг: Дундговь, Өлзийт 5-р баг, Рашаант, Булгийн 1-112  
Утас: (+976) 88000012, Утас/Факс: (+976) 7748514  
Э.ууудан: [ochirmandalhairkhan@gmail.com](mailto:ochirmandalhairkhan@gmail.com)


*2022 04 08*

22/42

Хүсэлт гаргах нь:

“Очир мандал хайрхан” ХХК нь Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших MV-021920 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг бөгөөд тус талбайд уурхайн кемпийн зориулалттай 4 га газар эзэмших эрхийн зөвшөөрөл олгож өгнө үү.

ЗАХИРАЛ



Б.БАТБАЯР





ДУНДГОВЬ АЙМАГ  
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/105

Рашаант

Ус ашиглуулах тухай

Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 12 дугаар ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өлзийт сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт байршилтай МУ-020438 ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 0811001097 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй “Очир мандал” ХХК-д кемпээс зүүн урагш 4 километр байх “Шарангад” нэртэй энгийн уурхайн худгийг унд ахуйн зориулалт болон тоосжилт дарах хэрэглээнд ашиглуулсугай.

2. Усаа зориулалтын дагуу ашиглан, усны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж байхыг “Очир мандал” ХХК-ний гүйцэтгэх захирал (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

3. Дээрх компанид ус ашиглах гэрээ байгуулан хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Жадамба)-д үүрэг болгосугай.

4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг “Очир мандал” ХХК-ний гүйцэтгэх захирал (Б.Батбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАСРАНДОРЖ

4/21/22, 12:38 PM

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын  
2016 оны 11 дүгээр сарын 30 –ны өдрийн  
а/44 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ЦАГААН ДЭРС  
ОРД (БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР)-ЫН 2022  
ОНЫ АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**



Ашигт малтмалын төрөл: Хайлуур жонш  
Үндсэн АТЗ-ийн дугаар: MV-021920  
Нэмэлт АТЗ-ийн дугаар:

ХЯНАСАН: УУСХ-ийн ахлах мэргэжилтэн

*Ц.Өнөрнасан*  
2022.04.26.

**БОЛОВСРУУЛСАН:**

1. Ерөнхий инженер *Дун*
2. Уулын инженер *Кү*
3. Баяжуулагч инженер *А.Монг*
4. Механик инженер *Камсрэл*
5. Эдийн засагч *В.Торамжав*

2022 он